  - C. Нэг нүд хараатай, тэр нүдний торлогт уйлан хайцарт өөрчлөлттэй
  - D. Торлогт ховхролт үүссэн
  - E. Дээрх бүгдэд кесар хагалгаа хийнэ
- /161./ Ургийн толгойн ямар тавилтын үед төрөх замаар төрөх боломжгүй вэ?
- A. Толгой оройгоор түрүүлэх
  - B. Өврийн тэнхэлгийн бус тавилт
  - C. Урд хэлбийлттэй нүүр түрүүлэлт
  - D. Толгой духаараа түрүүлэх
  - E. Толгойн их зулай түрүүлсэн үед
- /162./ Ихэс салсан үед илрэх Шредерийн шинж аль нь вэ?
- A. Хүйн огтолсон хэсэг унжих
  - B. Умайн ёроолын өндөр өөрчлөгдөх
  - C. Умдагны дээд талаар овойх
  - D. Умайн ёроол хэвэндээ байх
  - E. Хүй доош унжих
- /163./ Перинаталь анагаах ухаан гэдэг нь:
- A. Жирэмсний бүхий л хугацаанд ураг судлах
  - B. Төрсний дараах нярайн судлал
  - C. Жирэмсний 21 долоо хоног дотор ураг судлал
  - D. Жирэмсний 21 долоо хоногоос төрсний дараах 21 хоногт ураг нярай судлал
  - E. Жирэмсний 21-4 долоо хоногийн хугацааны ураг судлал
- /164./ Бүрэн биш зулбалтын үед ямар арга хэмжээ авах вэ?
- A. Булчин сулруулах эмчилгээ хийж хянана
  - B. Даавар эмчилгээ хийж хянана
  - C. Антибиотик эмчилгээ хийгээд мизопростол уулгана
  - D. Умайн хөндийг цэвэрлэнэ
  - E. Метотераксат тарина
- /165./ Хэвийн явцтай жирэмсний хожуу үед давсаг, шээс дамжуулах сувагт гарах өөрчлөлт
- A. Давсаг, шээс дамжуулах сувагт ямарч өөрчлөлт гарахгүй
  - B. Шээс дамжуулах суваг өргөсөж уртасна
  - C. Давсагны багтаамж нэмэгдэнэ
  - D. Шээс дамжуулах суваг богиносоно
  - E. Шээс дамжуулах суваг нарийсаж уртасна
- /166./ Жирэмсэн эхийн артерийн дээд доод даралтын зөрөө хэвийн үедээ хэд байх вэ?
- A. 40 мм МУБӨ-тэй тэнцүү байна.
  - B. 10-15 мм МУБӨ-тэй тэнцүү байна.
  - C. 15-25 мм МУБӨ-тэй тэнцүү байна.
  - D. 40-60 мм МУБӨ-тэй тэнцүү байна.
  - E. 60 мм-ээс дээш МУБӨ-тэй тэнцүү байна.
- /167./ Жирэмсний А/Д багадалтын үед шээсээр ялгарч, цусанд багасдаг бодисыг нэрлэнэ үү?
- A. 17 оксикортикостериод /17 ОКС/\*
  - B. Мочевин

- C. Шээсний хүчил
  - D. Уураг
  - E. Креатиник
- /168./ Манай улсад эх барихын тусламжыг хэдэн шатлалаар үзүүлдэг болохыг нэрлэнэ үү:
- A. Шатлал хамаарахгүй
  - B. 1 шатлалаар
  - C. 2 шатлалаар
  - D. 3 шатлалаар
  - E. 4 шатлалаар
- /169./ Бага аарцгийн гарах хэсгийн шулуун ба хөндлөн хэмжээнүүдийн зөв хэмжээг заана уу.
- A. 9,5 ;11 см
  - B. 8,5 ;10,5 см
  - C. 11,5 ;13 см
  - D. 10,5 ;12,5 см
  - E. 12,5 ;13 см
- /170./ Охидод бэлгийн бойжилт эрших хэлбэрээр эрт эхлэхэд хүргэх шалтгаан нь
- A. Бөөрний булчирхайн холтослог дааврын зузаарлаас
  - B. Бамбай булчирхайн үйл ажиллагааны хямрал
  - C. Өндгөвчийн киста
  - D. Өндгөвчийн кистома
  - E. Өндгөвчийн хавдар
- /171./ Леопольдийн 3-р аргаар юуг тодорхойлох вэ?
- A. Умайн ёроолын өндрийн түвшин
  - B. Ургийн байрлал, хэлбийлт
  - C. Түрүүлсэн хэсэг
  - D. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
  - E. Ургийн жин
- /172./ Дараах элэг-цөсний замын өвчний үед жирэмслэлтийг үргэлжлүүлж болох хувилбарыг хэлнэ үү?
- A. Идэвхтэй үедээ байгаа элэгний архаг үрэвсэл
  - B. Элэгний хатингаршил
  - C. Шарлах шинж тэмдэгтэй, халууралтай, сэдрэлтэй архаг явцтай холецистит
  - D. Цөсний чулуужилт
  - E. Элэгний дутагдал
- /173./ Ураг нүүрээр түрүүлсэн үед янзыг юугаар тодорхойлох вэ?
- A. Их зулай, духны заадасны байрлалаар
  - B. Нуруулалтаар
  - C. Эрүүний байдлаар
  - D. Хөмсөг, нүдний аяганы нумны байрлалаар
  - E. Бага зулайгаар
- /174./ Хэвийн явцтай жирэмсэн үед биеийн жин хэдэн кг нэмэгдэх вэ?
- A. 8 кг
  - B. 6 кг
  - C. 4 кг
  - D. 10-12 кг
  - E. 15-16 кг
- /175./ Жирэмсний эрт хугацаанд аяндаа зулбах үндсэн шалтгааныг нэрлэнэ үү:
- A. Цусны бүлгийн үл тохироо
  - B. Хүнд юм өргөх
  - C. Умайд соривтой байх
  - D. Хромосомын гажиг
  - E. Умайн хүзүүний дутмагшил
- /176./ Жирэмсэн эхийн артерийн даралт жирэмсний эхний хасагт өөрчлөгдөх үү?
- A. Артерийн даралт ихсэнэ
  - B. Артерийн даралт 20 мм МУБӨ-өөр буурна
  - C. Артерийн даралт 10 мм МУБӨ-өөр буурна

- D. Артерийн даралт өөрчлөгдөхгүй  
E. Артерийн даралт 30 мм МУБӨ-өөр буурна
- /177./ Артерийн даралт ихдэх өвчний үед хавчуур тавих заалт:  
A. Криз өгч хүндрэх  
B. Тархины цусны эргэлтийн алдагдал илрэх  
C. Артерийн даралт ихсэх өвчний 2 Б үе  
D. Зүрхний титэм судасны дутмагшил илэрхий илрэх  
E. Дээрх тохиолдол бүгдэд нь хавчуур тавина
- /178./ Умайн ерөндөгийг хэдийд тавих нь тохиромжтой вэ?  
A. Сарын тэмдэг ирсэн эхний өдөр.  
B. Сарын тэмдэгийн дунд үе  
C. Сарын тэмдэг ирэхийн өмнө.  
D. Сарын тэмдэг ирсэн 3-5 дахь өдөр  
E. Бэлгийн хавьталд орохын өмнө
- /179./ Мянганы хөгжлийн зорилтод 8 асуудал дэвшүүлснээс хүний эрүүл мэндийг сайжруулахтай холбоотой ямар асуудлыг дэвшүүлсэн бэ?  
A. ХДХВ/ДОХ, хумхаа, сүрьеэ зэрэг халдварт өвчнийг багасгах  
B. Мэдрэлийн өвчнийг багасгах  
C. Зүрх судасны өвчнийг багасгах  
D. Иод дутагдлыг багасгах  
E. Архидалтыг багасгах
- /180./ Ихэс ховхроход хүргэх голлох шалтгааныг нэрлэнэ үү:  
A. Хэвлийн гэмтэл  
B. Хожуу хордлого  
C. Илүү тээлт  
D. Ус их байх  
E. Хүй богино байх
- /181./ Аарцгийн хэвийн хэмжээг нэрлэнэ үү:  
A. 22-25-29-18 см  
B. 25-28-31-20 см  
C. 27-27-29-18 см  
D. 23-25-28-17 см  
E. 25-28-30-17 см
- /182./ Биений юмны мөчлөгийн ямар шатанд эстроген даавар хамгийн өндөр түвшинд ялгарах вэ?  
A. Эм бэлгийн эс боловсорч гүйцэх үед  
B. Эм бэлгийн эс гадагшилах үед  
C. Шар бие боловсрох үед  
D. Биений юм ирэхээс 2-3 хоногийн өмнө  
E. Биений юм ирэх үед
- /183./ 40-45 насны нэмэгтэйчүүдэд жирэмслэхээс хамгаалах эмүүдээс тохиромжтой нь:  
A. 1 шатлалтай дааврын хавсарсан эм  
B. 2 шатлалтай дааврын хавсарсан эм  
C. 3 шатлалтай дааврын хавсарсан эм  
D. Гестагены бага тун хэрэглэнэ  
E. Гестагены их тун хэрэглэнэ
- /184./ Цус алдалтын дайрлагын II зэрэгтэй байхад шингэнг нэг хоромд ямар хурдаар юүлэх вэ?  
A. 30-50мл  
B. 50-70мл  
C. 70-100мл  
D. 300-350мл  
E. Ач холбогдолгүй
- /185./ Леопольдийн 2-р аргаар юуг тодорхойлох вэ?  
A. Умайн ёроолын өндрийн түвшин  
B. Ургийн байрлал, хэлбийлт

- C. Түрүүлсэн хэсэг
- D. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
- E. Ургийн жин

/186./ 7 настай охины биеийн хөгжил насандаа тохирсон, харин үтрээнээс нь биеийн юм төст ялгарал гарна. Бэлгийн боловсролын бусад шинж тэмдэггүй, урьдчилсан байдлаар оношийг тогтооно уу?

- A. Өндгөвчийн гаралтай бэлгийн эрт бойжилт
- B. Төвийн гаралтай бэлгийн эрт бойжилт
- C. Өндгөвчийн дааврын идэвхижил бүхий хавдар
- D. Бэлгийн бойжилт удамшлын чанартай жинхэнэ эрт эхлэж буй
- E. Ямарч өөрчлөлт илрээгүй

/187./ Ургийн үе жирэмсний аль хугацаанаас эхэлдэг болохыг нэрлэнэ үү?

- A. Эхний нэг сарын төгсгөл
- B. Хоёрдох сард
- C. Гурав дахь сарын эхээр
- D. Гурав дахь гурван сарын төгсгөлөөр
- E. Дөрвөн сарын эхээр

/188./ Урд хэлбийлт дагзны түрүүлэлтийн үед хөтлөх цэг нь юу вэ?

- A. Их зулай
- B. Бага зулай
- C. Дагзны төвгөр
- D. Дагзны хонхор
- E. Дух

/189./ Жирэмсэн эхийн умайн ёроолын өндөр 33 см, гэдэсний эргэн тойрон 95 см байвал ойролцоогоор хэдэн долоо хоногтой жирэмсэн бэ?

- A. Жирэмсний 19-20 долоо хоногтой
- B. Жирэмсний 24-25 долоо хоногтой
- C. Жирэмсний 28-29 долоо хоногтой
- D. Жирэмсний 38-39 долоо хоногтой
- E. Жирэмсний 15-18 долоо хоногтой

/190./ Жирэмсний хурц өөхөн гепатозын үед СЦТБ хам шинжийн ямар өөрчлөлт гарах вэ?

- A. Өөрчлөгдөхгүй
- B. Төмөр дутагдлын цус багадалт болно
- C. Энэ шинж тэмдэг тод илэрнэ
- D. Артерийн даралт гэнэт ихсэнэ
- E. Артерийн даралт буурна

/191./ Ургийн уушигны хөгжлийг сайжруулах зорилгоор хийх эмчилгээнд аль нь хамаарах вэ?

- A. Сульфат магни
- B. Агчил тавиулах
- C. Глюкокортикоид
- D. Кальц хлорид
- E. Даралт бууруулах эм

/192./ Ургийн толгой бага аарцгийн орох амсрын дээр байхад Леопольдын IV байрлалаар ямар байх вэ?

- A. Ургийн толгойн оройгоор эмчийн гарын хуруу орохгүй боловч толгой аарцгийн дээр тэмтрэгдэнэ
- B. Ургийн толгойн оройгоор эмчийн гарын хуруу хоёр талаасаа нийлнэ
- C. Толгой тэмтрэгдэхгүй
- D. Бага аарцгийн орох аарцгийн дээр ургийн толгойн багахан
- E. Ургийн толгой хөдөлгөөнтэй байна

/193./ Жирэмсний эрт хугацааг хэт авиан шинжилгээний юуг үндэслэн тогтоох вэ?

- A. Ургийн зүрхний цохилтоор
- B. Ургийн хөдөлгөөнөөр
- C. Ургийн зулай-ахар сүүлний уртаар
- D. Ургийн толгойн их хөндлөн хэмжээгээр
- E. Ургийн чөмөгт ясны уртаар

/194./ Дутуу төрөлт гэдэгт аль хугацаа хамаарах вэ?

- A. Жирэмсний 20 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
- B. Жирэмсний 22 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
- C. Жирэмсний 24 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
- D. Жирэмсний 26 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
- E. Жирэмсний 28 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл

/195./ Дараах аргуудаас алийг оношлогооны бүх тохиолдолд хэрэглэдэг вэ?

- A. Генеологийн
- B. Цитогенетикийн
- C. Биохимийн
- D. Эс судлалын
- E. Иммуногенетикийн

/196./ Ургийн жинг тодорхойлох найдвартай арга

- A. Эхийн өндөр
- B. Хэт авиан шинжилгээ
- C. Рентген шинжилгээ
- D. Уламжлалт арга
- E. Эхийн биеийн жин

/197./ Жирэмсэн 29 настай, бага зэрэг халуурна, цусанд цагаан бөөмний тоо ялимгүй олширсон, СОЭ түргэссэн, АСЛО, С реактив уураг идэвхжилтэй бол хэрлэгийн идэвхжилийн хэддүгээр зэрэгт хамаарах вэ?

- A. A I зэрэг
- B. A II зэрэг
- C. A III зэрэг
- D. B I зэрэг
- E. B II зэрэг

/198./ Жирэмснээс хамгаалах депо-провераг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?

- A. Биений юм ирсэн 3 дахь өдөр.
- B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
- C. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа булчинд тарина.
- D. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
- E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.

/199./ Хэвийн байрласан ихэс цагаас өмнө ховхролтыг оношилох мэдээлэл сайтай арга аль нь вэ?

- A. Эх барихын гадуур үзлэг
- B. Үтрээний үзлэг
- C. Хэт авиан оношилгоо
- D. Ургийн зүрхний үйл ажиллагааг үнэлэх
- E. Цусны бүлэгнэлтийг тодорхойлох

/200./ *Conjugata externa* – гэдэг нь:

- A. 2 сүүжний дэлбээ ясны алслагдсан зай
- B. Дэлбээ ясны урд дээд төвгөрийн хоорондын зай
- C. Умдагны гадна дээд ирмэгээс ууцны хонхорын хоорондох зай
- D. Ууцны товгор болон умдаг ясны доод ирмэгийн хоорондын зай
- E. Умдагны доод ирмэгээс ууцны хонхор хүртлэх зай

/201./ Үтрээний хэвийн орчин нь:

- A. pH 4-5
- B. pH 6-7
- C. pH 7-8
- D. pH 9-10
- E. pH 1-2

/202./ 35-40 насны эмэгтэйчүүд жирэмсэлтээс хамгаалах эм хэрэглэхийг ямар үед эрс хориглох вэ?

- A. Тромбо-эмболийн өвчнүүдтэй бол
- B. Хөхүүл байх үед
- C. Хэрлэгийн идэвхжилтэй бол



- D. Таргалалттай бол
- E. Биений юмны хямралтай бол

/203./ Хавчуур тавих нөхцөл бүрдсэн тохиолдлыг заана уу?

A. Ураг амьд, шингэний бүрхүүлгүй, умайн амсар 6,0см нээлттэй, ургийн толгой баруун ташуу

B. Ураг амьд, шингэний бүрхүүлгүй, умайн амсар бүрэн нээгдсэн, аарцгийн хэмжээ хэвийн, ургийн толгой аарцгийн өргөн хэсгийн хавтгайд их сегментээр тавигдсан

C. Ураг амьд, умайн амсар бүрэн нээгдсэн, шингэний бүрхүүл хагараагүй, эхийн аарцаг хэвийн, ургийн толгой гарах хэсгийн шулуун хэмжээтэй давхацсан

D. Ургийн зүрхний цохилт сонсогдохгүй, умайн амсар бүрэн нээгдсэн, шингэний бүрхүүлгүй, эхийн аарцаг хэвийн, суман заадас гарах хэсгийн шулуун хэмжээтэй давхацсан

E. Нөхцөл шаардлагагүй

/204./ Леопольдийн 1-р аргаар юуг тодорхойлох вэ?

A. Умайн ёроолын өндрийн түвшин

B. Ургийн байрлал

C. Түрүүлсэн хэсэг

D. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал

E. Ургийн жин

/205./ Охидод биений юм анх ирэхэд нөлөөлөх гол хүчин зүйл нь:

A. Бие мах бодийн ерөнхий хөгжлийн гүйцэл

B. Гонадотропины хоногт ялгарах хэм ойртож, хэмжээ ихсэх

C. Биеийн жин 40 кг хүрч, өөхлөгийн эзлэх хувийн жин 15-18% болох

D. Өндгөвчинд үрийн цэврүү болрвсорч эм үр гадагшлах

E. Биеийн жин хэт ихсэх

/206./ Аль нь ургийн гадаад орчин болдог вэ?

A. Хорион

B. Умай

C. Шар уутанцар

D. Аллантоис

E. Амнион

/207./ Төрөх үеийн хэвийн цус алдалтын эрүүл, эмгэгийн зааг ямар хэмжээтэй байдаг вэ?

A. 800

B. 100

C. 150-300

D. 400

E. 500

/208./ Жирэмсэн болмогц шээсэнд хамгийн түрүүн илэрдэг дааварыг тодруулна уу?

A. Тестостерон

B. Эстрадиол

C. Эстриол

D. Цэлмэнгийн гонадотропин

E. Альфаретопротейн

/209./ Жирэмсний төгсгөлд тарган эмэгтэйн биеийн жингийн нэмэгдэлт ямар байх вэ?

A. Тарган биш эмэгтэйнхтэй адилхан жин нэмэгдэнэ /10 мг орчим/

B. Биеийн жин 10-15 кг-аар нэмэгдэнэ

C. Биеийн жин хэт ихсэнэ /15-аар их/

D. Хэвийн жинтэй эмэгтэйнхээс харьцангуй бага нэмэгдэнэ /6-7 кг/

E. Жирэмсний явцад жин огт нэмэгдэхгүй

/210./ Жирэмсний илүү тээлтийн үед эх барих үзлэгээр илрэх онцлог шинж тэмдэг

A. Ургийнхөдөлгөөн ихсэх

B. Ургийн хөдөлгөөн багасах

C. Ургийн зүрхний цохилт хэвийн байх

D. Хэвлийн эргэн тойрон нэмэгдэхгүй байх

E. Хэвлийн эргэн тойрон ихсэх

/211./ Нярайг эрт амлуулах:

- A. Төрсний дараа шууд
- B. Төрснөөс хойш 30 хормын дотор
- C. 4-5 цагийн дараа
- D. Эхийг төрсний дараах өрөөнд шилжүүлсний дараа
- E. Хугацаа хамааралгүй

/212./ Ургийн хүзүүг хүй ороосныг оношлох сорил:

- A. Окситоцины сорил
- B. Фонокардиографийн шинжилгээ
- C. Чанд авиан Гонын сорил\*
- D. Хүчил-шүлтийн суурийн өөрчлөлтөөр
- E. Эхийн ургийг рентгенээр шинжлэх

/213./ Ургийн жинг тодорхойлох Бубличенкогийн арга гэж юу вэ?

- A. Эхийн биеийн жингийн 20/1-тэй тэнцүү
- B. Гэдэсний эргэн тойрон умайн ёроолын өндөрийн үржвэртэй тэнцүү
- C. Умайн ёроолын өндөртэй тэнцүү
- D. Гэдэсний эргэн тойронг 2-т хуваасантай тэнцүү
- E. Умайн ёроолын өндөрийг 2-оор үржүүлсэнтэй тэнцүү

/214./ Ямар үед зүрхний өвчтэй эмэгтэйд гликозид хэрэглэх вэ?

- A. I хоромд зүрхний агшилт 70, амьсгал 18 удаа байхад
- B. I хоромд зүрхний агшилт 115, амьсгал 24-өөс дээш болвол
- C. Зүрхний агшилт 88, амьсгал 20 болбол
- D. Зүрхний агшилт 70, амьсгал 30 болбол
- E. Зүрхний агшилт 80, амьсгал 18 болбол

/215./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?

- A. Биений юм ирсэн 3 дах өдөр.
- B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
- C. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа булчинд тарина.
- D. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
- E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.

/216./ Мянганы хөгжлийн зорилтод 8 асуудал дэвшүүлснээс хүний эрүүл мэндийг сайжруулахтай холбоотой ямар асуудлыг дэвшүүлсэн бэ?

- A. Эхийн эндэгдлийг бууруулах
- B. Хүнсний хангамжийг сайжруулах
- C. Цус багадалтыг бууруулах
- D. Бичиг үл мэдэх явдлыг багасгах
- E. Жендерийн асуудал

/217./ Төрсний дараах үе гэдэг нь:

- A. Төрсний дараах эхний 24 цаг
- B. Төрснөөс хойш 4 долоо хоног
- C. Төрснөөс хойш 8 долоо хоног
- D. Төрсний дараа эхний 2 цагаас 4 долоо хоног хүртэл
- E. Төрснөөс хойш 72 хоног

/218./ Кольпоцитологийн шинжилгээг дараах оношилгоонд хэргэлэнэ:

- A. Жирэмсэн үеийн эстроген дааврын ханалтыг дам аргаар тодорхойлох
- B. Үтрээний цэвэршилтийн зэргийг тогтоох
- C. Умайн хүзүүнээс бактери илрүүлэх
- D. Ургийн гаж хөгжлийг илрүүлэх
- E. Ургийн шингэн гарсан эсэхийг тодорхойлох

/219./ Пролактин даавар хаана боловсорч ялгарах вэ?

- A. Өндгөвчинд
- B. Умайд
- C. Өнчин тархинд
- D. Хөхний булчирхай
- E. Харааны товгор

- /220./ Жирэмслэхээс хамгаалахаар хэрэглэдэг гестагены бага тунгийн үйлчлэх механизм нь:
- A. Өндгөвчийг ажиллуулахгүй
  - B. Өнчин тархины гонадотропиныг дарангуйлна
  - C. Үрийн хоолойн хөдөлгөөний идэвхийг алдагдуулна
  - D. Умайн хүзүүний салсыг шингэрүүлнэ
  - E. Умайн салстыг хөнгөтүүлнэ
- /221./ Эх барихын хавчуур тавих гэж ямар үйлдлийг хэлэх вэ?
- A. Төрөх замаар амьд ураг авах үйлдэл
  - B. Цусны даралт ихтэй эхэд дэмжлэг үзүүлэх үйлдэл
  - C. Төрөх хүчний сулралыг эмчлэх үйлдэл
  - D. Базалт, дүлэлтээс бүрэн чөлөөлнө
  - E. Дүлэлтийн хүчийг орлох үйлдэл
- /222./ Ихэс түрүүлэлтийг ямар шинжилгээгээр оношийг батлах вэ?
- A. Үтрээний үзлэг
  - B. Рентген шинжилгээ
  - C. Цистографи
  - D. Чанд авиан шинжилгээ
  - E. СТ
- /223./ Үр хөврөлийн эхийн биетэй холбогдох тэр үйл явцыг юу гэж нэрлэх вэ?
- A. Гастрүляци
  - B. Ихэсжих
  - C. Имплантаци
  - D. Эмбриогенез
  - E. Үр тогтох
- /224./ Хэвийн үед Мак-Клюра-Олдричийн сорил хэдэн хором байх вэ?
- A. 10 хором
  - B. 45 хором
  - C. 1 цаг 30 хором
  - D. 2 цаг
  - E. 2 цаг 30 хором
- /225./ Умайн гадуурх жирэмсний үед хамгийн эрт илрэх шинж тэмдэг
- A. Цус багадалт шинжүүд
  - B. Бөөлжилт илрэх
  - C. Сарын тэмдэг хоригдох
  - D. Сарын тэмдэг хоригдоогүй
  - E. Артерийн даралт багасах
- /226./ 4000,0-аас дээш том жинтэй хүүхэд төрүүлдэг өгүүлэлтэй жирэмсэн эмэгтэйд глюкоз задлах байдлыг тодруулах сорил хийхэд цусны сахар өлөн үед 120 мг%, 1 цагийн дараа 180 мг% байв.
- A. Сорил хэвийн
  - B. Чихрийн шижин илэрсэн
  - C. Сорил өөрчлөлттэй
  - D. Сорилыг давтан хийх
  - E. Сорил өөрчлөлтгүй
- /227./ Шульцын арга гэж юу вэ?
- A. Салсан ихсийг гаргах арга
  - B. Умайгаас ихэс яаж салсныг мэддэг арга
  - C. Ихэс салсан эсэхийг шалгадаг арга
  - D. Төрөхийн өмнө ургийн жинг тодорхойлдог арга
  - E. Ихэс гаргах арга
- /228./ Жирэмсний дутуу төрөлт гэсэн нэр томъёоны тухай ойлголт
- A. Жирэмсний 12 долоо хоног хүртэлх зулбалт
  - B. Жирэмсний 16-18 долоо хоног хүртэлх зулбалт
  - C. Жирэмсний 36 хоногоос хойш төрөх
  - D. Жирэмсний 22-37 хоног хүртэлх төрөлт
  - E. Жирэмсний 39 долоо хоногтой төрөлт

- /229./ Төрсний дараах үеийн үргэлжлэх хугацаа :
- A. 7 хоног
  - B. 2 долоо хоног
  - C. 4 долоо хоног
  - D. 5 долоо хоног
  - E. 6 долоо хоног
- /230./ Жирэмсний хожуу хугацаанд ургийн гажиг хөгжлийг найдвартай оношлох аргыг нэрлэ:
- A. Генетикийн шинжилгээ
  - B. Биохимийн шинжилгээ
  - C. Хэт авиан шинжилгээ
  - D. Гажиг хөгжилтэй ураг төрүүлдэг анамнезтай
  - E. Хэт авиан ургийн шилэн хүзүүний шингэнийг оношлох
- /231./ Артерийн даралт ихсэх өвчний ямар шатанд дотор эрхтнүүдэд өөрчлөлт гарч эхлэх вэ?
- A. I үе Б шат
  - B. II үе А шат
  - C. II үе Б шат
  - D. III үе А шат
  - E. III үе Б шат
- /232./ Трихомоназ үтрээний үрэвслийн үед шаардлагагүй эмийг нэрлэнэ үү:
- A. Трихопол
  - B. Метронидазол
  - C. Метрогел
  - D. Клотримазол
  - E. Клион
- /233./ 2000 оны 9 сард Нью-Йорк хотноо НҮБ-ын гишүүн хэдэн орны төр засгийн тэргүүн оролцож “Мянганы хөгжлийн зорилт”-ыг баталсан бэ?
- A. 29
  - B. 147
  - C. 110
  - D. 90
  - E. 70
- /234./ Илүү тээлтийг оношилоход эхний ээлжинд юуг зайлшгүй хийх шаардлагтай вэ?
- A. ЭХО –р ургийн байрлалыг тодруулах
  - B. Жирэмсний жинхэнэ хугацааг тогтоох
  - C. Ургийн зүрхний цохилтыг тодорхойлох
  - D. Ургийн шингэний хэмжээг тогтоох
  - E. Умайн агшилтыг үнэлэх стресс сорил хийх
- /235./ Биений юм ямар нөхцөл бүрэлдэж цус аяндаа зогсох вэ?
- A. Шар бие сөнөрч, даавар багассантай холбоотой
  - B. Умайн агшилт ихэссэнээс
  - C. Умай томорч судас дарагдснаас
  - D. Шинэ ургийн цэврүү хөгжиж даавар ялгаруулж эхэлсэнтэй
  - E. Цусны бүлэгнэлт ихэссэнтэй
- /236./ Жирэмслэхээс хамгаалах 1-шатлалтай дааврын эмийн үйлчлэх механизм нь:
- A. Умайн салстын хөвсийлтийг саатуулна
  - B. Өндгөвчийн ажиллагааг бууруулна
  - C. Өнчин тархинд гонадотропин үүсч ялгарахыг дарангуйлна
  - D. Гипоталамусын релизинг шүүрлийн хэмнэлийг алдагдуулна
  - E. Өндгөвчийн ажиллагааг идэвхжүүлнэ
- /237./ Дайрлагын индексийг тодорхойлох:
- A. Судасны цохилтыг агшилтын даралтанд харьцуулна
  - B. Судасны цохилтыг сулралтын даралтанд харьцуулна
  - C. Судасны цохилтыг даралтын их, багын зөрөөний даралтанд харьцуулна
  - D. Судасны цохилтыг чамархайн артерийн даралтаар харьцуулна
  - E. Артерийн даралтаар тодорхойлно

/238./ Ихэс түрүүлэлтийн үндсэн шинж тэмдэг юугаар илрэх вэ?

- A. Өвдөх
- B. Цус алдах
- C. Ургийн ус эрт гарах
- D. Ургийн зүрхний цохилт хурдсах
- E. Хавагнах

/239./ Жирэмсэн үед умдагны үений хоорондох зай хэд см өргөсөж болох вэ?

- A. 0,1 – 0,3 см
- B. 0,4 – 0,6 см
- C. 0,7 – 0,9 см
- D. 1,0 – 1,2 см
- E. 1,3 – 1,5 см

/240./ Горвиц-Гегар, Гентерийн шинжийг ямар нөхцөлд хэрэглэдэг вэ?

- A. Ихсийг гаргахад
- B. Жирэмсэнг оношлоход
- C. Төрсний дараа умайд ирэлдэг шинж
- D. Жирэмсний сүүлийн сард илэрдэг
- E. Зулбах үед гардаг шинж тэмдэг

/241./ Умайн гадуурх гуурсан хоолойн жирэмсний үед хоолой хэдэн долоо хоногтой байхад ихэвчлэн хагарах вэ?

- A. Жирэмсний 10-11 долоо хоногтой
- B. Жирэмсний 9-10 долоо хоногтой
- C. Жирэмсний 6-7 долоо хоногтой
- D. Жирэмсний 3-4 долоо хоногтой
- E. Жирэмсний 1-2 долоо хоногтой

/242./ 4000,0-аас дээш том жинтэй хүүхэд төрүүлдэг өгүүлэлтэй жирэмсэн эмэгтэйд хийсэн ачаалалтай сорилоор цусны сахар өлөн үед 5,4 ммоль/л, цагийн дараа 12,5 ммоль/л, 2 цагийн дараа 8,4 ммоль/л байв.

- A. Сорил хэвийн
- B. Чихрийн шижин илэрсэн
- C. Сорил өөрчлөлттэй
- D. Сорилыг давтан хийх
- E. Сорил өөрчлөлтгүй

/243./ Төрөлтөд умай бэлтгэгдсэн эсэхийг ямар сорилоор үзэх вэ?

- A. Блохын сорил
- B. Шмидын сорил
- C. Дексаметазоны сорил
- D. Аль нь ч биш
- E. Прогестероны сорил

/244./ Давтан төрөгч эмэгтэйд умайн хүзүү цагт ямар хурдтайгаар нээгдвэл хэвийн гэж үзэх вэ?

- A. 1 цагт 0,2 см
- B. 1 цагт 0,5 см
- C. 1 цагт 0,7 см
- D. 1 цагт 1,5 см
- E. 1 цагт 3 см

/245./ Апгарын үнэлгээгээр юу үнэлэх вэ?

- A. Нярайн цус багадлтыг
- B. Нярайн бүтэлтийн зэргийг
- C. Нярайн хугацаа гүйцсэнийг
- D. Илүү тээлтийн шинжийг
- E. Дутуу нярайн амьсгалын үйл ажиллагааг

/246./ Бүрэлдсэн эвсэл үр хэдэн хоногийн дараа умайн хөндийн салст бүрхэвчэнд сууж эхлэх вэ?

- A. 14 хоног
- B. 21 хоног

- C. 7 хоног
- D. 30 хоног
- E. 28 хоног

/247./ Артерийн даралтыг чагнаж тодорхойлох аргыг хэний арга гэж нэрлэдэг вэ?

- A. Рива-Роччи
- B. Коротков
- C. Е.М.Тареев
- D. Мясников
- E. Бодяжина

/248./ Жирэмсэн үед доод хөндийн хураагуур судас дарагдах хам шинж юунаас шалтгаалах вэ?

- A. Артерийн даралт ихэссэнээс
- B. Артерийн даралт багассанаас
- C. Умай, ураг, ургийн шингэн зэргээс
- D. Зүрх судасны өвчнөөс
- E. Хэт таргалалтаас

/249./ Жирэмсний 37 долоо хоногтойд ямар нэгэн зовиургүйгээр үтрээнээс цус гарч байвал эхний ээлжинд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Цусны бүлэгнэлтийг тодорхойлно
- B. Үтрээнд толь тавьж харна
- C. Яаралтай кесар хагалгаагаар төрөлтийг шийднэ
- D. Төрөлтийг сэдээнэ
- E. Ургийн бүрхүүл хальсыг хагална

/250./ Биений юмны мөчлөгийн ямар шатанд умайн булчингийн салстын булчирхайд шүүрэл үүсэх вэ?

- A. Өндгөн эс боловсрох үед
- B. Өндгөн эс гадагшилах үед
- C. Шар бие боловсрох үед
- D. Биений юмны мөчлөгийн 25-28 дахь хоногт
- E. Биений юм үзэгдэх үед

/251./ Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд жирэмслэхээс хамгаалах зорилгоор ууж хэрэглэдэг дараахь дааврын эмүүдээс хамгийн тохиромжтойг нь хэлнэ үү?

- A. 1 шатлалтай дааврын эм
- B. 2 шатлалтай дааврын эм
- C. 3 шатлалтай дааврын эм
- D. Гестагены бага тун
- E. Гестагены их тун

/252./ Өвчтөн Н. 23 настай. Анхны жирэмслэлтээ хууль бусаар үр хөндүүлж халдвар хордлогын дайрлагын III зэрэгтэй хүлээн авахад орж ирлээ. Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Маш яаралтай мэс засалд оруулна
- B. Өргөн хүрээтэй антибиотик эмчилгээг хэрэглэнэ
- C. Эрчимт эмчилгээний тасагт хэвтүүлж шокоос гаргах эмчилгээ хийж дараа нь мэс засалд оруулна
- D. Үүсгэгчийг тодруулах шинжилгээ хийж хүлээх тактик баримтлана
- E. Эмчилгээг ерийн тактикаар хийнэ

/253./ Жирэмсний гарцаагүй шинж тэмдэг.

- A. Биений юм хоригдох
- B. Үтрээ болон умайн хүзүүний салст хөхрөх
- C. Хэвлийн цагаан шугам, хөхний толгой несөөтөх
- D. Ургийн хэсэг тэмтрэгдэх
- E. Огиулж бөөлжих.

/254./ Эх барихын хязсанд аль хэсэг хамрах вэ?

- A. Ахар сүүл арын заадасны хоорондох хэсэг
- B. Бэлгийн уруулын арын заадас болон хошногоны амсарын хооронд
- C. Хошног ахар сүүлний хооронд
- D. Умдагны доод ирмэгээс хошногоны амсар хүртэл



- Е. Шээсний сүвнээс хошногоны амсар хүртэл
- /255./ Орчин үед нярай хүүхдийн жин, өндөр ямар байхад төрөлт гэж тооцох вэ?
- А. 500гр-аас дээш жинтэй, 22см-ээс дээш урттай
  - В. 600гр-аас дээш жинтэй, 24см-ээс дээш урттай
  - С. 800гр-аас дээш жинтэй, 33см-ээс дээш урттай
  - Д. 1000гр-аас дээш жинтэй, 37см-ээс дээш урттай
  - Е. 1200гр-аас дээш жинтэй, 40см-ээс дээш урттай
- /256./ Кесар хагалгааны заалттай жирэмсэн эхийг хаана төрүүлэх нь эрсдэл багатай вэ?
- А. Сум, сум дундын эмнэлэг
  - В. Заавал тусгай анхаарал тавих шаардлагатай
  - С. II-III шатлалын эх барихын бус эмнэлэг
  - Д. Аймаг, төвлөрсөн төрөх газар
  - Е. Ямар ч шатлалын эмнэлэгт төрүүлж болно
- /257./ Тарган эмэгтэйн төрөлтийн үед ямар хүндрэл тохиолдох вэ?
- А. Идээт үжил
  - В. Зүрх судасны дутмагшил
  - С. Тромбоз
  - Д. Бөөрний хурц дутагдал
  - Е. Уушгины хурц дутагдал
- /258./ Өврийн янзтай дагз түрүүлэлтийн үед толгой гэдийхдээ юугаараа тулах цэг хийх вэ?
- А. Их зулай
  - В. Бага зулай
  - С. Дагзны төвгөр
  - Д. Дагзны хонхор
  - Е. Дух
- /259./ Ураг орчмын шингэн хэзээ гарвал хэвийн гэж үзэх вэ?
- А. Жирэмсний 39 долоо хоногтойгоос хойш
  - В. Жирэмсний дунших үед
  - С. Төрлөгийн I үе эхлэнгүүт
  - Д. Умайн хүзүү бараг бүрэн нээгдэх үед
  - Е. Умайн хүзүү 6 см нээгдснээс хойш
- /260./ Хойтхи салахгүй 30 хором болсон, цус алдалтгүй бол ямар тусламж үзүүлэх вэ?
- А. Дахин 30 хором ажиглана
  - В. Ихсийг Альфелдийн аргаар гаргана
  - С. Умайн агшаах бэлдмэл хэрэглэнэ
  - Д. Умайн хөндийг багажаар хусаж цэвэрлэнэ
  - Е. Ихэс гардаж гаргана
- /261./ Жирэмсний төгсгөлд умайгаар дамжин өнгөрөх цусны хэмжээ хэд дахин нэмэгдэх вэ?
- А. 30 дахин
  - В. 6-8 дахин
  - С. 300 дахин
  - Д. нэмэгдэхгүй
  - Е. 19-29 дахин
- /262./ Жирэмсний гестоз, даралт ихдэх өвчнөөс үл хамааран ямар тохиолдолд артерийн даралт нэмэгдэх вэ?
- А. Чихрийн шижин
  - В. Мендельсоны хам шинж
  - С. Иценко-Кушингийн хам шинж
  - Д. Аорт-Каваль хам шинж
  - Е. Эпиленси өвчин
- /263./ Сарын тэмдэг саатсан эмэгтэйд шээсэнд даавар ялгарах хамгийн бага хугацааг заана уу
- А. 14 хоног
  - В. 30 хоног
  - С. 40 хоног
  - Д. 50 хоног

Е. 5 хоног

- /264./ 36 настай 4 удаа төрсөн, эмэгтэйчүүдийн эмгэгээр өвдөж байгаагүй, доошоо цус гарна гэж ирсэн бол ямар шинжилгээг хийх нь чухал вэ?
- А. Бамбайн дааврын шинжилгээ
  - В. Гистеросальпингографи
  - С. Кольпоцитологи
  - Д. Бэлгийн даавар тодорхойлох
  - Е. Умайн салстыг хусаж цэвэрлэх
- /265./ Биений юм ирэхийн өмнөх хам шинжийн үндсэн эмчилгээг дурьдана уу?
- А. Даавар эмчилгээ
  - В. Мэдрэл-сэтгэцийн байдалд нөлөөлж тайвшруулах эмэн эмчилгээ
  - С. Дархлал заслын эмчилгээ
  - Д. Антибиотек эмчилгээ
  - Е. Өндгөвчийг хэсэгчлэн авах мэс заслын эмчилгээ
- /266./ Жирэмслэхээс хамгаалах зорилгоор бэлгийн харьцааны дараа ууж хэрэглэдэг постинорын найрлаганд ямар даавар агуулагдах вэ?
- А. Эстрогеныг бага тунгаар агуулна
  - В. Эстрогеныг их тунгаар агуулна
  - С. Гестагеныг агуулна
  - Д. Эстроген-гестагеныг агуулна
  - Е. Эстроген-гестаген агуулагдахгүй
- /267./ Ихэр жирэмслэлтийн үед тохиолдож болох хүндрэл
- А. Жирэмсний хожуу хордлого
  - В. Жирэмсэн эхийн сэтгэлийн хямрал
  - С. Цус багадалт заавал илрэнэ
  - Д. Ихэс түрүүлэлт болно
  - Е. Ургийн жин томроно
- /268./ Жирэмсний аль үеийн хордлого жирэмсний амь насанд илүү аюултай вэ?
- А. Жирэмслэлт бол физиологийн процесс тул амь насанд аюулгүй.
  - В. Жирэмсний эрт үеийн хордлого.
  - С. Жирэмсний хожуу үеийн хордлого.
  - Д. Жирэмсний эрт үеийн хордлого физиологийн процесс тул амь насанд аюулгүй.
  - Е. Жирэмсний хожуу үеийн хордлого физиологийн процесс тул амь насанд аюулгүй.
- /269./ Дааврын хавсарсан эмийн үйлчлэлийг нэрлэнэ үү
- А. Өндгөн эс боловсролтыг саатуулна
  - В. Умайн хүзүүний салиаг шингэрүүлнэ
  - С. Эр бэлгийн эсийн хөдөлгөөнийг хязгаарлана
  - Д. Умайн салстын шүүрлийн үйл ажиллагааг дарангуйлна
  - Е. ФСГ болон ЛГ харьцааг хэвийн болгоно
- /270./ Индекс Соловьевын мөн чанар юу вэ?
- А. Төрөлтөнд бэлтгэгдсэн байдлыг үзнэ
  - В. Ясны зузаан, нимгэн байдлыг тодорхойлно
  - С. Жирэмсний хугацааг тодорхойлох
  - Д. Ургийн хөдөлгөөнийг тогтоох арга
  - Е. Ургийн зүрхний цохилтыг чагнах арга
- /271./ Кесар хагалгаа хийлгэсэн жирэмсэн эхийг хэзээ хэвтүүлэх вэ?
- А. Төрөлтийн үйл ажиллагаа эхлэнгүүт
  - В. Ургийн шингэн гарангуут
  - С. Төрөхөөс өмнө 1 сарын өмнө
  - Д. Төрөхөөс өмнө 7-10 хоногийн өмнө
  - Е. Төрөхөөс өмнө хэвтүүлэх шаардлагагүй
- /272./ Чихрийн шижин өвчний үед ураг томрох, эд эсийн дутмагшил үүсэхэд юу нөлөөлөх вэ?
- А. Инсулин
  - В. Глюкоз
  - С. Нүүрс ус
  - Д. Зөв хооллолт

- Е. Хоол сойх
- /273./ Төрөлтийн II үе хэзээнээс эхлэх вэ?
- А. Ургийн түрүүлсэн хэсэг аарцагт бүрэн суух
  - В. Дүлэлт эхлэх
  - С. Ургийн толгой дотор эргэх
  - Д. Умайн амсар бүрэн нээгдэж ураг орчмын шингэн гарах
  - Е. Ургийн шингэн гарангуут
- /274./ Хэвийн биеийн жин, өндөртэй, 36 долоо хоногтой эмэгтэйн ихэр ургийг оношлох хамгийн магадлалтай үзлэг юу вэ?
- А. Дотуур үзлэг
  - В. Ургийн түрүүлсэн хэсэг толгой байх
  - С. Гэдэсний эргэн тойрон 100 см-ээс их
  - Д. Гэдэсний эргэн тойрон 90 см байх
  - Е. Гэдэсний эргэн тойрон 80 см байх
- /275./ Хэвийн төрөлтийн үед физиологи цус алдалт биеийн жингийн хэдэн хувьтай тэнцэх вэ?
- А. 0,3 %
  - В. 0,5 %
  - С. 0,7%
  - Д. 0,8 %
  - Е. 1%
- /276./ Эр бэлгийн эс хэвийн үед хэдэн цаг амьдрах вэ?
- А. 12-24 цаг
  - В. 24-32 цаг
  - С. 48-72 цаг
  - Д. 72-88 цаг
  - Е. 100-гаас дээш цаг
- /277./ Жирэмсэн үеийн интернатал ураг хамгаалал гэж юу вэ?
- А. Жирэмсний 21 долоо хоног дотор
  - В. Жирэмсний 21-36 долоо хоног
  - С. Жирэмсний зөвхөн 37-40 долоо хоног
  - Д. Төрөлтийн үйл ажиллагаа эхэлж, төрөх хүртлэх үеийн ураг хамгаалал
  - Е. Төрсний дараах үеийн ураг хамгаалал
- /278./ Жирэмсний хожуу хугацааг хэрлэгийн идэвхжилийн ямар үед жирэмсэнг үргэлжлүүлэх боломжгүй вэ?
- А. Хэрлэгийн идэвхжилийн I зэрэг
  - В. Лабораторийн үзүүлэлтэнд ялимгүй өөрчлөлт гарсан
  - С. Хэрлэгийн идэвхжил II зэргээс хэтэрч, цусны эргэлтийн III зэргийн алдагдал үүссэн
  - Д. Зірхний агшилт 78, амьсгал 40 удаа байх
  - Е. Зүрхний агшилт 68, амьсгал 18 удаа байх
- /279./ Умайн салстын цочмог үрэвслийн үед илрэх эмнэлзүйн гол шинж тэмдэг юу вэ?
- А. Халуурах
  - В. Сарын тэмдэг хаагдах
  - С. Хэвлийн доод хэсгээр хүчтэй өвдөх
  - Д. Сарын тэмдгийн мөчлөг байнга алдагдах
  - Е. Цусархаг шингэн байнга гарах
- /280./ Жирэмсэн болсныг шээсэнд байгаа ямар даавраар тодорхойлох вэ?
- А. Эстроген
  - В. Эстрон
  - С. Эстриол
  - Д. Цэлмэнгийн ганодатропин
  - Е. Тестостерон
- /281./ Умайн гуурсан хоолойн битүүрлийг шалгахад хамгийн мэдээлэл сайтай шинжилгээний аргыг нэрлэнэ үү
- А. Гистеросальпингографи

- В. Пневмопельвиографи
- С. Кульдоскопи
- Д. Лапароскопи
- Е. Пертубаци

/282./ Ургийн зүрхний цохилтыг чагнахад зайлшгүй хамааралтайг нэрлэнэ үү:

- А. Жирэмсний 12 долоо хоногтойгоос чагнана
- В. Төрөлтийн 1- үед цаг тутамд чагнана
- С. Хүйн баруун дээр тод сонсогдоно
- Д. Фонендоскопоор илүү сайн сонсогдоно
- Е. Дүлэлт болгоны дараа чагнана

/283./ Биений юм мөчлөгийн ямар шатанд прогестерон даавар хамгийн их/өндөр түвшинд байх вэ?

- А. Ургийн цэврүү боловсрох үед
- В. Ургийн цэврүү боловсорсны дараа
- С. Шар бие гүйцэд боловсрох үед
- Д. Биений юмны эхний өдөрт
- Е. Биений юмны сүүлийн өдөрт

/284./ Хламидийн халдварыг эмчлэхэд үр дүн сайтай эм нь:

- А. Пенициллины бүлгийн антибиотууд
- В. Тетрациклины бүлгийн антибиотууд
- С. Сульфаниламидын эмүүд
- Д. Нитрафураны эмүүд
- Е. Өвөрмөц антибиотууд

/285./ Цус алдалтын дайрлагын үед цусны ямар судсууд нарийсах вэ?

- А. Зах хязгаарын цусны судас
- В. Амьдралын чухал эрхтнүүдийн тэжээлийн судас
- С. Том хураагуур судас
- Д. Том тараагуур судас
- Е. Зүрхний титэм судас

/286./ Төмрийн бэлдмэлийг хүнд цус багадалттай эмэгтэйд төрөлт, үр хөндөлтийн дараа яаж уулгах вэ?

- А. Өдөрт хагас шахмалыг уулгана.
- В. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш уулгана.
- С. Өдөрт 1 шахмалыг уулгана
- Д. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уулгана.
- Е. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш уулгана.

/287./ Цэвэршилтийн дараа дааврын түвшин яаж өөрчлөгддөг вэ?

- А. Өөрчлөлт бага илэрнэ
- В. ФСГ болон ЛГ буурна
- С. ФСГ болон ЛГ нэмэгдэнэ
- Д. Пролактин нэмэгдэнэ
- Е. Прогестероны түвшин нэмэгдэнэ

/288./ Бие махбодид агуулагдаж байгаа цусны хэдэн хувь байнгын эргэлтэнд байх вэ?

- А. 90-100%
- В. 40-60%
- С. 20-30%
- Д. 70-80%
- Е. 100%

/289./ Жирэмсний хугацааг сарын тэмдэгээр яаж тодорхойлох вэ?

- А. Сүүлийн сарын тэмдгийн сар өдрөөс 3 сарыг хасч 10 хоног нэмнэ
- В. Сүүлийн сарын тэмдгийн сар өдрөөс 3 сарыг хасч 7 хоног нэмнэ
- С. Сүүлийн сарын тэмдгийн сар өдрөөс 3 сарыг хасч 7 хоног хасна
- Д. Сүүлийн сарын тэмдгийн сар өдрөөс 3 сарыг хасч 14 хоног нэмнэ
- Е. Сүүлийн сарын тэмдгийн сар өдрөөс 3 сарыг хасч 14 хоног хасна

/290./ Халдварт шар өвчтэй жирэмсэн эхийн жирэмслэлтийг таслах эсэхийг яаж шийдэх вэ?

- A. Жирэмслэлтийг тасласнаар эмнэлзүй хөнгөрнө
- B. Жирэмслэлтийг тасласнаар эмнэлзүй хүндэрнэ
- C. Жирэмслэлтийг таслах нь халдварт шар өвчин хөнгөрөх шалтгаан болдоггүй
- D. Жирэмслэлтийг таслах санаачлага ерөөс гаргах хэрэггүй
- E. Жирэмслэлийг яаралтай таслана

/291./ Жирэмсний гестоз, даралт ихдэх өвчнөөс үл хамааран ямар ховор тохиолдолд артерийн даралт нэмэгдэх вэ?

- A. Чихрийн шижин өвчин
- B. Иценко-Кушингийн хам шинж
- C. Мендельсоны хам шинж
- D. Аорт-Каваль хам шинж
- E. Уушигны сүрьеэ

/292./ Бөгс түрүүлэлтийн аль үед хамгийн их хүндрэл тохиолддог болохыг нэрлэнэ үү:

- A. Цэвэр өгзөг
- B. Холимог өгзөг
- C. Нэг хөлний буюу хөлний бүрэн биш түрүүлэлт
- D. 30 долоо хоногтой өгзөг түрүүлэлт
- E. 30 долоо хоногтой холимог өгзөг түрүүлэлт

/293./ Ураг орчмын шингэн жирэмсний 39-40 долоо хоногтойд хэдэн мл байвал хэвийн гэж үзэх вэ?

- A. 200 гр хүртэл
- B. 201-300 гр хүртэл
- C. 700-800 гр хүртэл
- D. 1,2-1,5 литр хүртэл
- E. 1,5 литрээс их байвал

/294./ Хүй унжих шалтгаан :

- A. Ургийн бүтэлт
- B. Шүргэлцэх бүслүүр үүсээгүй байх
- C. Төрөх хүчний сулрал
- D. Уйтан аарцаг
- E. Ихэс ховхрох

/295./ Дутуу төрөлтийн дараах тохиолдлуудаас алины нь үед төрөлийг яаралтай сэдээх вэ?

- A. 33-34 долоо хоногтой халдварын шинж тэмдэггүй ургийн шингэн эрт гарч эхэлсэн, ураг бүтэлтгүй
- B. 35 долоо хоногтой, төрөлтийн үйл ажиллагаа эхэлсэн, ургийн шингэн гараагүй, ураг бүтэлтгүй
- C. 32-33 долоо хоногтой, эх халуунтай, ургийн шингэн эрт гарсан, ураг бүтэлттэй
- D. 37 долоо хоногтой, хожуу анхан төрөгч, төрлөгийн үйл ажиллагаа эхэлж байгаа ургийн шингэн шүүрч байна
- E. 37 долоо хоногтой төрөлт эхэлсэн, ургийн шингэн гараагүй

/296./ Цусны эргэлтийн хямралын шинж баруун ховдлын үйл ажиллагааны алдагдлаар тод илэрч буй, хэрлэгийн А II зэргийн идэвхжилтэй, уушигны судасны II зэргийн даралт ихдэлттэй, дөнгөж үүссэн мерцаль хэм алдагдалтай эхчүүд өртөмтгийн хэддүгээр зэрэгт хамаарах вэ?

- A. Өртөмтгийн I зэрэг
- B. Өртөмтгийн III зэрэг
- C. Өртөмтгийн II зэрэг
- D. Өртөмтгийн IV зэрэг
- E. Өртөмтгийн V зэрэг

/297./ Умайн салстын архаг үрэвслийн үед илрэх эмнэлзүйн гол шинж тэмдэг юу вэ?

- A. Халуурах
- B. Сарын тэмдэг хаагдах
- C. Хэвлийн доод хэсгээр хүчтэй өвдөх
- D. Сарын тэмдгийн мөчлөг байнга алдагдах
- E. Цусархаг шингэн байнга гарах

/298./ Монгол улсад эх барихын эмэгтэйчүүд судлалаар анхны эрдэмтэн хэн бэ?

- A. М.Дамбадорж
- В. Б.Жав
- С. Д.Ичинхорлоо
- D. Ч.Шагдар
- Е. С.Дорж

/299./ Хэвийн явцтай жирэмсэн үед ямар шинжилгээг заавал хийх шаардлагагүй вэ?

- A. Серологийн сорил
- В. Цусны резус-фактор
- С. Гемоглобины хэмжээг тогтоох
- D. Цэлмэнгийн ганодотропин даавар тодорхойлох
- Е. Наалдац болон эсийн шинжилгээ

/300./ Биений юмны мөчлөгийн хэдий үеэс өндгөвч прогестерон даавар ялгаруулж эхлэх вэ?

- A. Ургийн цэврүү боловсорч эхлэх үед
- В. Ургийн цэврүү боловсорч гүйцэх үед
- С. Эм бэлгийн эс гадагшилсны дараа
- D. Эм бэлгийн эс боловсрох үед
- Е. Мөчлөгийн 22-26 дахь хоногт

/301./ Эмэгтэйчүүдийн бэлгийн замын хламидийн үрэвслийг илрүүлэх хамгийн тохиромжтой шинжилгээний арга нь:

- A. Үтрээний наацыг Романовскийн будгаар будаж шинжлэх
- В. Хламидийг өсгөвөрлөж шинжлэх
- С. Хламидийн эсрэг биеийг иммуноферментийн шинжилгээгээр илрүүлэх
- D. Хламидийг серологийн аргаар илрүүлэх
- Е. Үтрээний гаацын шинжилгээ

/302./ Ямар хэмжээний цус алдахад цус алдалтын дайрлагын III үе үүсэх вэ?

- A. 20-30%
- В. 25-40%
- С. 40-45%
- D. 60-70%
- Е. 70-80%

/303./ Төмрийн бэлдмэлийг хүнд цус багадалттай жирэмсэнд яаж уулгах вэ?

- A. Жирэмсний турш өдөрт хагас шахмалыг ууна.
- В. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш ууна.
- С. Жирэмсний турш өдөрт 1 шахмалыг ууна
- D. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш, цаашид жирэмсний турш 1 шахмалаар ууна
- Е. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш ууна.

/304./ Доорхи эмгэгээс аль нь үсэрхийлэх хандлага илүүтэй байдаг вэ?

- A. Тератома
- В. Ийлдэст цистоаденом
- С. Эндометриоид уйланхай
- D. Папиллярний цистоаденом
- Е. Муцинозний цистоаденом

/305./ Жирэмсний төгсгөлд эргэлдэх цусны хэмжээ хэдэн граммаар нэмэгдэх вэ?

- A. <900,0-1000,0
- В. 1100,0-1200,0
- С. 1500,0-1600,0
- D. >1600,0
- Е. >2000,0

/306./ Төрсний дараах эрт үед дундчаар хэдэн мл цус алдах вэ?

- A. 300 мл
- В. 200 мл
- С. 400 мл
- D. 500 мл
- Е. 600 мл

/307./ Хадуур эст цус багадал буюу НВ эмгэг юунаас болж үүсдэг вэ?

- A. НВ-ны молекулд глютамины хүчил валинаар солигдсоноос



- В. НВ-ны молекулд валины хүчил глутаминаар солигдсоноос  
С. НВ-ны молекулд глутамины хүчил лизинээр солигдсоноос  
D. НВ-ны молекулд гистасины хүчил валинаар солигдсоноос  
E. НВ-ны молекулд глутамины хүчил гисталинаар солигдсоноос
- /308./ Хэлээ амнаас гүйцэд гарахгүй, хахаж цацна. Хэлний булчин хатингир.
- A. Бульбар саа  
B. Хуурамч бульбар саа  
C. Хэлний дорхи мэдрэлийн саа  
D. Хэл залгиурын мэдрэлийн ян  
E. Зажлуурын булчингийн саа
- /309./ Баруун гар тохойгоор нугарч, сарвуу дотогш эргэсэн. Баруун хөл явахад чирэгдэж даялна.
- A. Вернике-Маннын байрлал  
B. Ромбергийн тэнцвэргүйдэл  
C. Steppage алхаа  
D. "Тамгалсан алхаа"  
E. "Мэлхий байрлал"
- /310./ Хуурамч бульбар сааны үед гэмтэх бүтцүүд:
- A. IX, X, XII хосын бөөмс  
B. IX, X, XII хосын кортико-нуклеар зам  
C. IX, X хосын мэдрүүл  
D. Nucleus dorsal  
E. Nucleus ambiguus
- /311./ Унтаад сэрэхэд баруун гарын сарвуу унжсан. I, Y хурууг ойртуулах боломжгүй. Гэмтэл бэртэлд ойрд өртөөгүй. Үзлэгээр: Сарвуугаа гэдийлгэж чадахгүй. Сарвууны ар тал I-III хурууны харалдаа өвдөлтийн мэдрэхүй буурсан. Таны урьдчилсан онош:
- A. Мөрний сүлжээний доод салааны эмгэг  
B. n.radial гэмтсэн  
C. Мөрний сүлжээний дээд салааны эмгэг  
D. n.ulnar гэмтсэн  
E. n.median гэмтсэн
- /312./ Баруун гар огт хөдлөхгүй, тонус, гүний рефлексүүд арилсан. Мэдрэхүй хэвийн.
- A. сул саа  
B. чангарсан саа  
C. талсаа  
D. тэнцвэргүйдэл  
E. анестези
- /313./ Залуу оройн хоолны дараа гэнэт толгой өвдөж, огъж бөөлжиж, ухаан алдаж, хүлээн авах тасагт хүргэгдсэн. Ходоод цэвэрлэх, хордлого тайлах эмчилгээнд үр дүнгүй. Зайлшгүй илрүүлэх хамшинж:
- A. Пирамидын  
B. Сул сааны  
C. Полиневропатийн  
D. Ёзоорын  
E. Мэнэнгийн
- /314./ Хөхүүл охин, 6 сартай, толгойн тойрог 47см. Их зулай том, чинэрч лугшина. Грефе-н шинж тод үүснэ.
- A. Гавлын даралт ихсэлт-тархи усжилтын хамшинж  
B. Сульдаа  
C. Бамбайн хордлого  
D. Тэжээлийн доройтол  
E. Мэдрэл хордлогын хамшинж
- /315./ Хавирганы нум орчмоор хатгаж өвдөнө. Өвдөлт амьсгал авах, найтаахад ихэснэ. Хэвлийн дээд рефлекс үүсэхгүй.
- A. Ёзоорын хамшинж  
B. Хавирга завсрын мэдрэлийн өвдөлт

- C. Бүслүүр ярын ян
- D. Уушигны хатгалгаа
- E. Цээжний өвдөлт

/316./ Баруун гар, мөр, цээжний баруун хагаст өвдөлт, t° мэдрэхүй арилсан. Мэдрэхүй алдагдсан хэвшинж:

- A. Ёзоорын хэвшинж
- B. дисталь хэвшинж
- C. Сегментын хэвшинж
- D. Дамжих хэвшинж
- E. Мононеврит хэвшинж

/317./ Баруун гар унжсан, мөр бугалганы булчин шуурч хатингиршсан. 2 ба 3 толгойт булчингийн шөрмөсний рефлексүүд үүсэхгүй. Мэдрэхүй хэвийн.

- A. Нэг мөчний чангарсан саа
- B. Нэг мөчний сул саа
- C. Дежерин-Клюмпке-гийн саа
- D. Эрба-Дюшенны саа
- E. Сувгийн хамшинж

/318./ Сэтгэцийн эмгэгтэй хүнийг харах хандах үүрэгтэй асран хамгаалагч асрах үүргээ умартаж тухайн өвчтөнийг дэр мэдэн эмнэлгээс гарган явуулсан тохиолдолд уг этгээд нийгэмд аюултай үйлдэл хийвэл хариуцлага алдсан этгээд ямар хуулийн зүйл ангиар хариуцлага хүлээлгэх вэ?

- A. ЭХ-ийн 263 дугаар зүйлд заасан байдаг
- B. ЭХ-ийн 265 дугаар зүйлд заасан байдаг
- C. ЭХ-ийн 269 дугаар зүйлд заасан байдаг
- D. ЭХ-ийн 262 дугаар зүйлд заасан байдаг
- E. ЭХ-ийн 267 дугаар зүйлд заасан байдаг

/319./ Өглөө сэрэхэд баруун сарвуу унжсан. Урьд орой нь архи уусан. Таны тавих урьдчилсан онош:

- A. N.radial невропати
- B. Тохойн сувгийн хамшинж
- C. Мөрний сүлжээний эмгэг
- D. N.medianus невропати
- E. Полиомиелит

/320./ Зүүн нүдний ухархай руу цоргиж, хатгаж өвдөнө. Хүчтэй өвдөлтийн дараа нүднээс нулимс гоожиж, гэрэлд гялбасан. Нүдний эвэрлэг, дух, хуйханд цэврүүт тууралт гарч, шархалсан. Баруун нүд гүйцэд анигдахгүй. Баруун хацраар хий алдана.

- A. Гурвалсан мэдрэлийн ян
- B. Глаукомын хөдлөл
- C. Гассер зангилааны өвдөлт
- D. Мигренийн хөдлөл
- E. Эвэрлэгийн үрэвсэл

/321./ Зүүн гар бугуйн үеэр хөдлөхгүй, бугалга шууны дотор талаар чиг хуруу чиглэж өвдөлтийн мэдрэхүй буурсан. Гар янгинаж өвдөнө.

- A. нугас өмнөд эвэр C5-C7
- B. нугасны арын эвэр C 5-C7
- C. мөрний сүлжээ C7-Th1
- D. мөрний сүлжээ C5-C6
- E. нугасны бүтэн огтлол C5-C6

/322./ Нэг настай хөхүүл хүүхдийн толгойн тойрог 40см. Нүүр толгойн харьцаа алдагдсан. Байнга уйлагнана. Таны урьдчилсан онош:

- A. Микроцефали
- B. Гидроцефали
- C. Макроцефали
- D. Дизэмбриогенези
- E. Гипоксийн энцефалопати

/323./ Сул сааны үед гэмтэх бүтцүүд

- A. Нугасны арын эвэр
- B. Нугасны өмнөд эвэр
- C. Нугасны хажуу эвэр
- D. Ganglion spinal
- E. Premotor cortex

/324./ Цээжний баруунд эгмээс хавирганы нум хүртэл өнгөц, t° мэдрэхүй буурсан. Мэдрэхүй алдагдсан хэвшинжийг нэрлэнэ үү.

- A. Дамжих хэвшинж
- B. Хязгаарын хэвшинж
- C. Ёзоорын хэвшинж
- D. Сегментын хэвшинж
- E. Дисталь хэвшинж

/325./ Сэтгэлийн хөдөлгөөн тогтворжуулах эмийг нэрлэнэ үү?

- A. Амитриптиллин
- B. Галоперидол
- C. Лити карбонат
- D. Амисулпирид
- E. Зуклопентоксил

/326./ Хүний хэлснийг ойлгох боловч, өөрөө ярьж чадахгүй. Залгих рефлекс хэвийн.

- A. Ойлгохын хэлгүйдэл
- B. Ярихын хэлгүйдэл
- C. Анартри
- D. Дизартри
- E. Бульбар саа

/327./ Ахмад настай эрэгтэй хүнд юм өргөх үед цээжээр хатгаж, амьсгаа авах, найтах, ханиахад түвэгтэй. Зүрхний бичлэг хэвийн. АД 130/80мм.МУБ. Таны урьдчилсан онош:

- A. Ёзоор татагдлын өвдөлт
- B. Зүрхний бах
- C. Уушигны багтраа
- D. Бүсэлхийн радикулопати
- E. Архаг бронхит

/328./ Баруун үе үе татагнаж булчин татна. Аажмаар суларч, явахад чирэгдэнэ. Бабинскийн рефлекс баруунд тод. Өвдөг, борвины рефлекс өндөр d>s.

- A. өмнөд төв атираа зүүнд
- B. арын төв атираа зүүнд
- C. нугасны арын эвэр L1-L5
- D. нугасны өмнөд эвэр L1-L5
- E. нугас талласан L1-L5

/329./ Хүний сэтгэхүй хэдээс хэдэн насны хооронд бүрэлдэн тогтдог вэ?

- A. 20-25
- B. 18-22
- C. 22-25
- D. 20-22
- E. 18-25

/330./ Нугасны өмнөд эврийн гэмтлийн шинж тэмдэг

- A. Захын саа
- B. Хорнерын шинж
- C. Төвийн саа
- D. Хуурамч бульбар саа
- E. Бульбар саа

/331./ Өсвөр насны залуу зүүн хөлөө чирж явна, нуруу хазайсан. 2 хөлийн гуя, өгзөгний булчин хатингар, зүүн талдаа илүү шуурсан. Зүүн хөлийн хөгжил хоцорсон.

- A. Энцефалитын үлдэц
